

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нарийн бичиг Н.Нандинцэцэг хурлын ирцыг танилцууллаа. Хурлын ирц 71%. Хурал 10:00 минутад эхэлсэн. Хурлын дарга Ч.Чинзориг хурлыг нээсныг мэдэгдлээ.

Ч.Чинзориг: Төлөөлөн удирдах зөвлөлөөс ХЭХ –г 2017 оны 3-р сарын 7-ны өдөр хуралдуулахаар тогтоосоны дагуу хурал эхлэж байгааг мэдэгдье. Хурлаар 11 асуудал хэлэлцэх ба хэлэлцэх асуудлуудыг дэс дагаарааг нь танилцуулаад саналаа аваад явъя. Хурлын материал дээр хурлын дэг, хурлын хэлэлцэх асуудлуудыг оруулсан байгаа.

Хэлэлцэх асуудал 1. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайлан, Төлөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг танилцууллаа.

М.Ганболд: Асуух зүйл байна. Одоогоор Баян-Алдар ХК нь яг ямар үйл ажиллагаа явуулж байгаа вэ. Тариалалтыг хийхэд өрөнгө мөнгөний асуудлыг яаж шийдэж байгаа талаар

Ч.Чинзориг: Манай компани нь Завхан аймагт анх үүсгэн байгуулагдсан бөгөөд 2014 онд Улаанбаатар хотруу шилжүүлэн авсан ба ямар ч хөрөнгө мөнгөгүй ирсэн. Компанийг идэвхтэй байлгаж, үйл ажиллагаа явуулж, тариалалтыг эхлүүлэхэд маш их зардал мөнгө шаардагддаг. Жишээлбэл булцуутын үрийг Япон улсад шинжилгээнд явуулахад 50,000 еэн буюу Монгол мөнгөөр 1 сая гаран төгрөг болдог /2015 онд анхны дээжийг илгээсэн/. Яагаад тариалалт хийсэн бэ гэвэл байгалд ээлтэй органик бүтээгдэхүүн гаргах зорилготой байсан ба 2016 оны тариалалтаар 60 гаран кг ургац хураасан ба түүнээсээ Япон улсад 2015, 2016 оны монголд ургасан дээжийг тус тусад нь шинжилгээнд явуулсан байгаа. Мөн Булцуутын навчыг хатаан цай 2 өөр савлагаатайгаар шинжилгээнд явуулсан.

Түүнчлэн МОНОС компанийн лабораторид хоёр жил тариалласан дээжүүдийг он он тус бүрээр нь шинжилгээнд өгсөн.

Хэлэлцэх асуудал 2. Команийн аудитлагдсан тайлан, ТУЗ-н дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг П.Чинзориг танилцууллаа.

П.Чинзориг: Компанийн аудитыг “Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК-иар хийлгүүлсэн ба энэ компани нь олон компанийн аудитыг хийдэг туршлагатай компани учираас ТУЗ аудит хорооноос сонгон хийлгүүлсэн байгаа.

Хэлэлцэх асуудал 3. 2017 оны 1-р сарын 25 ны өдрийн 17/01 тоот ТУЗ-ийн ноогдол ашиг хувиарлахгүй тухай тогтоолыг танилцууллаа. Компани нь 2016 онд 21,489,990 төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Ч.Чинзориг: Ер нь ногдол ашиг хувиарладаг, ашигтай ажилладаг компани болохын тулд ББСБ үүсгэн байгуулахаар 2015 оны ХЭХ-р шийдвэрлэсэн боловч хууль эрх зүйн үүднээс нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татан ББСБ-г үүсгэн байгуулахад хүндрэлтэй

байсан учир компанийг ББСБ-тай нэгтгэх нь зүйтэй гэж ТУЗ-ын зүгээс ХЭХ-д санал оруулж байгаа юм.

Хэлэлцэх асуудал 4. Компанийг өөрчлөн байгуулах, нэгтгэх тухай ТУЗ-өөс оруулсан саналыг хэлэлцэх

Ч.Чинзориг: Хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хувиарладаг, ашигтай ажилладаг компани болохын тулд ББСБ үүсгэн байгуулахаар 2015 оны ХЭХ-р шийвэрлэсэн боловч нэмэлт хувьцаа гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгөөр ББСБ-г үүсгэн байгуулахад хууль эрх зүйн үүднээс зохицуулалт хийхэд учир дутагдалтай байгааг СЗХ-ноос зөвлөж байсан юм. Мөн нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татан ББСБ-г үүсгэн байгуулахад цаг хугацааны хувьд болон компанийн боловсон хүчний хувьд дутмаг зүйлүүд их байсан. Иймд өөрийн 100 хувь эзэмшдэг Банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг компанитай нэгтгэхээр ТУЗ-д санал оруулсны дагуу 2017 оны 1-р сарын ТУЗ-ийн зүгээс дэмжиж нэгтгэхийг дэвшүүлэн ХЭХ-д санал оруулж байгаа юм.

М.Ганболд: Хороо Банк бус санхүүгийн байгуулахад хүндрэлтэй байна гэсэн ББСБ-тай нэгдэхэд зүгээр үү

Ч.Чинзориг: Нэгдэхийг бол Санхүүгийн зохицуулах хорооноос. Ард санхүүгийн нэгдэл гэх мэт том компаниуд маань нэгдээд бирж дээр материалаа бүртгүүлэх гээд өгчихлөө. Тэгэхлээр ийм жишээнүүд гараад эхэлчихсэн байгаа учраас энэ замыг сонгосон юм.

Ингээд компанийг нэгтгэх нь зүйтэй гэсэн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу “Сикап ҮЦК” ХХК-тай гэрээ байгуулаад урьдчилсан судалгаануудыг хийлгэж байгаа. Хуулийн дүгнэлт, аудитын дүгнэлт, үнэлгээний ажлуудыг Санхүүгийн зохицуулах хороонд зөвшөөрөлтэй компаниудтай хамтран ажиллаж байгаа. Компани нэгдсэнээр нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт татах боломж бүрдэж цаашид компанийн цар хүрээ нэмэгдэж, нийтэд нээлттэй үйл ажиллагаагаа явуулж жил бүр хувьцаа эзэмшигчидэдээ ногдол ашиг хувиарлах боломжтой компани болох юм.,

Нэгдэх гэж байгаа “Монгорүматрикс Гинко ББСБ” ХХК нь 2013 онд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгосны дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа туршлагатай компани юм.

Хэлэлцэх асуудал 5. Компанийн нэр солих талаар хэлэлцэх

Ч.Чинзориг: Энэ асуудалыг компани нэгдэхэд компанийн нэрийг Банк бус санхүүгийн байгууллагын нэрээр буюу “Монгорүматрикс Гинко ББСБ” ХК гэж солихыг хэлэлцэхээр оруулсан юм. Гишүүд дэмжих эсэх саналаа саналын хуудсаар өгнө үү.

Хэлэлцэх асуудал 6: Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэх

Ч.Чинзориг: Компанийн дүрэмд ямар өөрчлөлт оруулах вэ гэвэл нэгэнт компани өөрчлөн байгуулахаар нэгтгэж байгаатай холбоотой нэмэлт хувьцаа гаргах асуудал гарна. Тэгэхлээр нэмэлт хувьцаа гаргана гэдэг маань нилээн ажил гардаг учраас компанийнхаа зарласан хувьцааны дүнг өөрчлөх саналыг энэ хурлаар оруулж байгаа юм. Үүнтэй холбоотой хэлэлцэх асуудал 7, 8 –р асуудлууд нь хөндөгдөж байгаа юм.

Ингээд компанийн дүрмийн 4.1 дэх заалт буюу компанийн зарласан хувьцааны тоог 30.000.000 /гучин сая/ ширхэг, үүнээс 28.000.000 /хорин найман сая/ ширхэг давуу эрхийн хувьцаа, 2.000.000 /хоёр сая/ ширхэг энгийн хувьцаа болгон нэмэгдүүлэх санал оруулж байгаа юм.

Хэлэлцэх асуудал 7: Хувьцааг хуваах буюу нэгтгэхийг хэлэлцэн батлах

Компани нь “Монгорүматрикс Гинко ББСБ” ХХК-тай нэгдсэнээр компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваахад компанийн зарласан тухайн төрлийн хувьцааны тоонд орох өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулахыг хэлэлцэхээр оруулсан юм.

Хэлэлцэх асуудал 8: Нэмэлт хувьцаа гаргах талаар хэлэлцэн батлах

Ч.Чинзориг: Компанийг нэгтгэсний дараа хувьцаа нэмж гарган хөрөнгө оруулалт татах талаар хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар оруулж хэлэлцүүлэн шийдвэр гаргах шаардлагатай болсон. Яагаад гэвэл компани нэгдсэний дараа хийгдэх ажлуудыг энэ хурлаараа хэлэлцэж хувьцаа эзэмшигчид зөвшөөрч байгаа эсэхээс компанийн нэгдэх асуудал шийдэгдэх тул нэг нэгэнгүй оруулан хэлэлцүүлж байгаа юм.

Хэлэлцэх асуудал 9: Өрийг хувьцаагаар солих талаар хэлэлцэн батлах

Компани нь 2014 - 2017 онуудад үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүднээс Ч.Чинзоригоос 70,000,000 төгрөгийг зээлсэн. Тус өрийг компанийн одоогийн явуулж байгаа үйл ажиллагаанаас ашиг олоод буцаан төлөхөд маш их хугацаа шаардлагатай байгаа тул өрийг хувьцаагаар солих талаар хэлэлцэж шийдвэрлүүлэхээр оруулсан байгаа юм.

Ш.Таро: Компани хувьцаа нэмж гаргахдаа 70 сая төгрөгийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэн барагдуулах нь зөв болов уу гэж бодож байна.

Хэлэлцэх асуудал 10: Компанийн хэлбэр өөрчлөх

Компанийн хувьцааг 20% -иас дээш хувийг гадаадын иргэн эзэмшдэг бол компанийн хэлбэр /гадаадын хөрөнгө оруулалттай/ өөрчлөгдөх эсэх талаар УБЕГ-аас хэд хэдэн удаа лавласан боловч эргээд хариу өгнө гээд хариу өгөөгүй. Хэрэв өөрчлөгдөх бол хувьцаа эзэмшигчдын хурлаараа хэлэлцэж шийдвэрлэхгүй бол дараа дараагийн гарах ажлуудад хүндрэл гардаг учир Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалдаа оруулсан байгаа юм. Гэтэл УБЕГ-аас хурлын зар гарсны дараа УБЕГ-аас хариу ирсэн. Хувьцаат компани учираас компанийн хэлбэр өөрчлөгдөхгүй гэсэн хариу өгсөн. Тийм учраас энэ хэлэлцэх асуудлыг хэлэлцэхгүй боллоо.

Хэлэлцэх асуудал II: Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийн томилгоог хүчингүйд тооцох, нэр дэвшүүлэх, томилох

Ч.Чинзориг: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн И.Наоко, хараат бус гишүүн Б.Ганболд, Б.Энх-Амгалан нар нь төлөөлөн удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооноос дараах хүмүүсийг нэр дэвшүүлсэн байгаа. Ердийн гишүүнээр Ш.Таро, хараат бус гишүүнээр Ч.Даваазориг, А.Лодойравсал. Нэр дэвшигч нарын танилцуулга нь хурлын материал дээр байгаа учир хувьцаа эзэмшигч нар танилцаад саналын хуудсанд саналаа өгнө үү.

Ч.Чинзориг: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу?

М.Ганболд: Өнгөрсөн жил нийт хувьцаат компанийн 63% нь хурлаа зарласан байсан. Мөн 62 хувьцаат компанийн эрхийг Санхүүгийн зохицуулах хорооноос цуцалсан. Хувьцаат компаниудын ихэнх хувь нь идэвхгүй, үйл ажиллагаа явуулахад хөрөнгө мөнгөгүйгээсээ болоод олон компани дампуурч байна. Компанийн хувьд мөн адил хөрөнгө мөнгөгүй байсан ч үйл ажиллагаагаа идэвхжүүлэх үүднээс олон ажил төлөвлөөд хийх гэж байгаад баяртай байна. Компанийн мэдээлэл нээлттэй байх нь хувьцаа эзэмшигчдэд итгэл төрүүлдэг ба Ард санүүгийн нэгдэл, Монгол шуудан ХК нэгдсэнээр мэдээлэл нээлттэй болж, компанийн эрэлт, үнэлгээ сайжирч байгаа нь харагдаж байгаа юм.

Ч.Чинзориг: Бид хувьцаа эзэмшигчдээ тогтмол ногдол ашиг хуваарилдаг ашигтай, тогтвортой компани болж Компанийн засаглалыг хэвшүүлэх, хөрөнгийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг компани болохыг зорин ажиллах болно.

Ч.Чинзориг: Тооллогын комисс саналын хуудсаа хурааж аваад тооллогын дүнг гаргаад танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Л.Очирмаа байна: 2017 оны 3-р сарын 7-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн асуудлуудын саналын дүнг танилцуулъя

Хэлэлцэх асуудал 1: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 2: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 3: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 4: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 5: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 6:Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 7:Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 8:Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал 9:Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хэлэлцэх асуудал II: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 71 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа

Хурлын дарга Ч.Чинзориг: Нийт хэлэлцсэн асуудлууд санал хураалтын тооллогын дүнгээр 71%буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдсан байна. Тогтоолын төслийг танилцуулаад батлаад явъя гэж бодож байна.

Хэлэлцэх асуудал 7, 8-р асуудлуудыг дүрэмд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зөвшөөрсөн тул шийдвэр гаргахгүй байхаар тогтлоо.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 6 тогтоол баталлаа.

Хурал хаасныг мэдэгдье: 11:25 минутад

Хурлын тэмдэглэл хөтлөсөн:

/Хурлын нарийн бичгийн дарга/



